Киноны төрөл зүйл

Бид уламжлал ёсоороо киноны төрөл зүйлүүдийг дахин шигшин өөрчилсөн юм.

Энэ жил Детектив / Цагдаатай (*Detective / Cop),* Хүчирхэг эмэгтэйн дүр (*Film de Femme),* Хошигнолт баримтат (*Mockumentary*) *болон* Дуугүй (*Silent Film)* хасагдаж оронд нь Гэмт хэрэг/Гангстер *(Crime/Ganster)* болон Эндүүрэл (*Mistaken Identity*) орууллаа.

Мөн 48 цаг кино наадмыг *Мюзикл юмуу Вестерн (Musical or Western)* төрөл зүйлгүйгээр төсөөлөхөд бэрх билээ.

Уран бүтээлчид хийх киноныхоо төрөл зүйлийг сонгосны дараа, нэг л удаа дахин оноолтын төрлөөр солих эрхтэй. Нэг удаа сольсон л бол дахин сонгох эрхгүй! Дахин солих буюу оноолтын эрхийн картыг хот бүрт өөр өөр байхаар хуваарилдаг. (**Доорх жагсаалтыг харна уу**)

Багууд кино хийх төрөл зүйлээ сугална.

- Нөхөрлөлийн тухай (Buddy Film)
- Инээдмийн (Comedy)
- Гэмт хэрэг/Гангстер (Crime/Gangster)
- Эмгэнэлт инээдмийн (Dark Comedy)
- Драм (Drama)
- Фантаз (Fantasy)
- Аймшиг (Horror)
- Эндүүрэл (Mistaken Identity)
- Мюзикл эсхүл Вестерн (Musical or Western)
- Романтик / Хайр сэтгэлтэй (Romance)
- Шинжлэх ухааны зөгнөлт (Sci Fi)
- Баатарлаг (Superhero)
- Триллер (Thriller/Suspense)
- Амралтын эсвэл Баярын өдөртэй (Vacation or Holiday Film)

Хэрэв танай баг Мюзикл юмуу Вестерн (Musical or Western) сугалбал, энэ хоёрын аль нэгээр нь Мюзикл Вестерн (Musical Western) ч юмуу бүр Вестерн Мюзикл (Western Musical) ч хийж болно.

Киногоо сугалсан төрөл зүйлдээ сайн тохируулж хийх хэрэгтэй. Сугалсан төрөл зүйлээ бусад багтай солихыг эрс хориглоно.

Харин олон төрөл зүйлийг хольж хийж болно. Жишээлбэл: Инээдмийн, дуугүй, нөхөрлөлийн тухай кино (silent comedic buddy film)

2013 онд дахин солих буюу оноолтын карт

- Адал явдалтай цуврал (Adventure Serial)
- Нөхөрлөлийн тухай кино (Buddy Film)
- Эрийн цээнд хүрч буй/Эр хүн болж буй (Coming of Age)
- Гэр бүлийн (Family Film)
- Дээрэм/Хулгай (Heist)
- Эртний, түүхэн (Period Piece)
- Цаг хугацааны аялал (Time Travel Movie)

Хүчирхэг эмэгтэйн дүр (Film de Femme)

Урьд нь хүчирхэг эмэгтэйн дүр (Film de Femme) гэсэн төрөл зүйлийн талаар сонсож байгаагүй юу? Яагаад гэвэл бид зохиосон юм. Энэ нь 48 цаг кино наадмын кинонуудад хүүхнүүдэд зориулсан хүчирхэг дүр оруулахад зориулан тусгайлан гаргасан төрөл юм. Хайр сэтгэлийн инээдмийн, мөн “chick flick” буюу хүүхнүүдэд зориулсан кинонууд энэ төрөлд багтах боловч зөвхөн багахан хэсэг нь юм.

Хүчирхэг эмэгтэйн дүр гэдэг нь юу вэ? “JUNO”-гийн Ellen Page, “Frida” –гийн Salma Hayek, “Election” –ний Reese Witherspoon, “Erin Brockovich” –гийн Julia Roberts –гийн дүрүүдийг бод. Ээдрээтэй мөн ухаалаг. Эмэгтэйчүүд зөвхөн эрчүүдийн ажлыг хийж байгаагаар дүрслэхээс зайлсхийх хэрэгтэй. Олонхийн боддогчлон хүчтэй гэхээр л заавал хүн алдаг байх шааардлагагүй.

Олдсон бичлэг (Found Footage)

Олдсон бичлэг буюу Found Footage нь киноны нэгэн үндсэн төрөл бөгөөд энэ төрлийн үйл явдал нь санамсаргүйгээр олдсон бичлэг маягаар үргэлжилдэг ба зарим тохиолдолд эерэг талын баатрын хийж үлдээсэн бичлэг мэтээр дүрслэгдэнэ.

Ихэнх тохиолдолд үйл явдал гол дүрийн камераар бичсэн бичлэгээр дамжин үргэлжилдэг. Гэхдээ үүнээс гадна өөр олон төрлийн, хяналтийн болон нууц камераар хийсэн бичлэгнүүд байж болно.

Олны танил кинонуудаас жишээ татахад: The Blair Witch Project (1999), Paranormal Activity (2007) болон Cloverfield (2008).

Бүх бичлэгнүүд нь хэдий олдсон мэд дүрслэгдэх боловч, 48 цагийн дотор авсан байх шаардлагатай. Бүтээл нь заавал аймшгийн төрлийн байх шаардлагагүй.

Operetta

Бүх харилцан яриаг дуулах хэрэгтэй.